

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	6
3.	Аудитын тайлан.....	9
3.1	Ерөнхий зүйл	9
3.2	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	10
3.4	Материаллаг байдал.....	10
3.5	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1	Мөнгөн хөрөнгө	11
3.5.2	Авлага.....	11
3.5.3	Урьдчилгаа	12
3.5.4	Бараа материал	12
3.5.5	Үндсэн хөрөнгө	12
3.5.6	Өр төлбөр	13
3.5.7	Засгийн газрын хувь оролцоо.....	13
3.5.8	Зардлын данс.....	14
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	14
3.7	Шилэн дансны мэдээлэл	15
3.8	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.9	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	16
3.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	17
4.	Менежментийн захидал	18
4.1	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	18
4.2	Балансын холбоотой асуудал	18
4.3	Балансын данстай холбоотой асуудал	19
4.4	Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал.....	19
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СХЗХ	Стандарт, хэмжил зүйн хэлтэс
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БИЛГҮҮН ТАНАА

2021.03.25 № 01/391
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын баримт бичигтэй холбоотой 5 зорилт, 9 арга хэмжээний хэрэгжилт 93.0 хувь, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 3 зорилт, 3 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 6 зорилт, 17 арга хэмжээний хэрэгжилтийг 96.7 хувьтай гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,039.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,745,401.0	1,567,871.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,699.1	8,390.7
33	АВЛАГА	170,911.4	140,829.0
34	УРЬДЧИЛГАА	-	50,418.2
35	БАРАА МАТЕРИАЛ	1,564,716.5	1,367,433.5
36	НӨӨЦИЙН БАРАА	7,074.0	800.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,428,692.6	6,922,567.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,428,692.6	6,922,567.4
39200	Биет хөрөнгө	4,847,428.5	6,336,457.3
39300	Биет бус хөрөнгө	581,264.1	586,110.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,174,093.6	8,490,438.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,624.2	54,589.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,624.2	54,589.2
41300	Өглөг	32,164.2	54,589.2
41400	Урьдчилж орсон орлого	460.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,141,469.4	8,435,849.6
51	Засгийн газрын хувь оролцоо	7,141,469.4	8,435,849.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,180,931.6	6,906,931.3
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,097,967.6)	(536,869.2)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,058,505.4	2,065,787.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,174,093.6	8,490,438.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,074,771.5	13,484,196.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,073,487.0	8,885,647.8
120	Нийтлэг татварын бус орлого	5,073,487.0	8,885,647.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,001,284.5	4,598,549.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,581,594.4	12,164,369.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,581,594.4	12,164,369.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,238,856.1	7,280,798.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,895,070.4	4,456,597.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	486,746.7	588,498.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	328,132.2	358,365.6
2104	Хангамж, бараа материалын зардал	201,131.8	340,447.2
2105	Норматив зардал	104,459.4	121,575.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,450.5	193,569.3
2107	Томилолт, зочны зардал	176,442.3	165,710.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	194,443.7	222,812.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	801,979.2	833,221.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,342,738.2	4,883,571.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	493,177.1	1,319,827.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,553.0	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,249.1	765,275.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	489,481.0	554,552.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	12,556,229.1	11,563,914.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,543,044.5	5,414,850.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,013,184.6	6,149,064.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,980,236.7	10,683,814.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,980,236.7	10,683,814.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,623,668.0	7,420,166.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,903,950.6	4,449,159.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	485,537.9	595,202.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,349.3	374,623.4
2104	Хангамж, бараа материалын зардал	168,789.8	255,764.6
2105	Норматив зардал	104,618.0	162,009.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,412.3	951,765.1
2107	Томилолт, зочны зардал	168,566.6	167,473.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	255,329.1	272,945.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,114.5	191,221.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,356,568.7	3,263,648.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	575,992.5	880,099.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	578,441.1	874,408.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	578,441.1	874,408.2
2200	Дотоод эх үүсвэрээр	578,441.1	874,408.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(578,441.1)	(874,408.2)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(2,448.6)	5,691.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,147.7	2,699.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,699.1	8,390.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,652,495.2	6,652,495.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(403.8)	(403.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,652,091.3	6,652,091.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(103.0)	(103.0)
9	Тайлант үеийн үр дүн	489,481.0	489,481.0
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,141,469.4	7,141,469.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,545.9	6,545.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,148,015.3	7,148,015.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	7,282.1	7,282.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	725,999.6	725,999.6
19	Тайлант үеийн үр дүн	554,552.6	554,552.6
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,435,849.6	8,435,849.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,603,167,400.00	8,443,961,191.56	159,206,208.44	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,223,167,400.00	8,071,728,292.56	151,439,107.44	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,788,296,100.00	7,668,594,587.96	119,701,512.04	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,466,886,500.00	4,431,724,973.06	35,161,526.94	99.2
210101	Үндсэн цалин	3,253,926,500.00	3,244,903,102.09	9,023,397.91	99.7
210102	Нэмэгдэл	972,602,000.00	940,925,739.55	31,676,260.45	96.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	240,358,000.00	245,722,881.42	(5,364,881.42)	102.2
210104	Урамшуулал	-	173,250.00	(173,250.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	602,006,000.00	593,588,843.72	8,417,156.28	98.6
210201	Тэтгэврийн даатгал	423,410,400.00	489,025,544.50	(65,615,144.50)	115.5
210202	Тэтгэмжийн даатгал	44,648,800.00	25,868,334.13	18,780,465.87	57.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,719,200.00	21,499,420.09	14,219,779.91	60.2
210204	Ажилгүйдлийн даатгал	8,929,800.00	5,194,226.64	3,735,573.36	58.2
210205	Эрүүл мэндийн даатгал	89,297,800.00	52,001,318.36	37,296,481.64	58.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	403,851,900.00	371,524,350.85	32,327,549.15	92.0
210301	Гэрэл, цахилгаан	104,394,500.00	99,045,960.80	5,348,539.20	94.9
210302	Түлш, халаалт	206,258,700.00	189,193,775.98	17,064,924.02	91.7
210303	Цэвэр, бохир ус	33,793,700.00	26,605,134.07	7,188,565.93	78.7
210304	Байрны түрээс	59,405,000.00	56,679,480.00	2,725,520.00	95.4
2104	Хангамж, бараа материалын зардал	261,230,000.00	256,204,630.87	5,025,369.13	98.1
210401	Бичиг хэрэг	52,563,600.00	52,124,180.00	439,420.00	99.2
210402	Тээвэр, шатахуун	97,720,400.00	95,655,873.00	2,064,527.00	97.9
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	49,280,100.00	48,975,941.07	304,158.93	99.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,236,900.00	6,243,574.00	993,326.00	86.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,429,000.00	53,205,062.80	1,223,937.20	97.8
2105	Нормативт зардал	155,830,100.00	154,420,204.68	1,409,895.32	99.1
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,691,300.00	126,524,104.68	167,195.32	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,138,800.00	27,896,100.00	1,242,700.00	95.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,271,928,000.00	1,270,251,198.20	1,676,801.80	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	343,568,000.00	343,156,189.20	411,810.80	99.9
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	33,750,000.00	32,828,163.00	921,837.00	97.3
210604	Урсгал засвар	891,610,000.00	891,266,846.00	343,154.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	176,430,800.00	161,793,530.00	14,637,270.00	91.7
210702	Дотоод албан томилолт	176,430,800.00	161,793,530.00	14,637,270.00	91.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	267,208,800.00	251,788,803.58	15,419,996.42	94.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,905,000.00	121,993,631.58	9,911,368.42	92.5

Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,103,400.00	4,526,200.00	1,577,200.00	74.2
210803	Даатгалын үйлчилгээ	6,890,100.00	5,945,560.00	944,540.00	86.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,691,200.00	1,961,551.00	729,649.00	72.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	744,900.00	590,000.00	154,900.00	79.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,078,300.00	20,963,687.00	114,613.00	99.5
210807	Газрын төлбөр	2,421,600.00	2,252,764.00	168,836.00	93.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,530,000.00	500,040.00	1,029,960.00	32.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	93,844,300.00	93,055,370.00	788,930.00	99.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,924,000.00	177,298,053.00	5,625,947.00	96.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,102,900.00	123,545,775.00	4,557,125.00	96.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,821,100.00	53,752,278.00	1,068,822.00	98.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	434,871,300.00	403,133,704.60	31,737,595.40	92.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	174,371,500.00	165,671,357.60	8,700,142.40	95.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	174,371,500.00	165,671,357.60	8,700,142.40	95.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	260,499,800.00	237,462,347.00	23,037,453.00	91.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	243,549,800.00	224,815,516.00	18,734,284.00	92.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,950,000.00	12,646,831.00	4,303,169.00	74.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	380,000,000.00	372,232,899.00	7,767,101.00	98.0
220001	Барилга байгууламж	380,000,000.00	372,232,899.00	7,767,101.00	98.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,603,167,400.00	8,443,959,791.56	159,207,608.44	98.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,281,489,200.00	4,258,160,316.00	23,328,884.00	99.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,281,489,200.00	4,258,160,316.00	23,328,884.00	99.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,321,678,200.00	4,185,799,475.56	135,878,724.44	96.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,261,678,200.00	4,184,165,383.56	77,512,816.44	98.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000,000.00	1,634,092.00	58,365,908.00	2.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,400.00	(1,400.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	773.00	767.00	6.00	99.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	21.00	21.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	21.00	21.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	376.00	373.00	3.00	99.2
620001	Удирдах ажилтан	28.00	28.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	229.00	226.00	3.00	98.7
620003	Үйлчлэх ажилтан	119.00	119.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	376.00	373.00	3.00	99.2
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	195.00	192.00	3.00	98.5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	181.00	181.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,933,987,114.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,904,737,314.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	222,697,288.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,434,866.70
210101	Үндсэн цалин	11,519,657.90
210102	Нэмэгдэл	4,325,980.80
210104	Урамшуулал	1,589,228.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,614,076.83
210201	Тэтгэврийн даатгал	1,507,265.14
210202	Тэтгэмжийн даатгал	26,702.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,362.34
210204	Ажилгүйдлийн даатгал	5,340.58
210205	Эрүүл мэндийн даатгал	53,405.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,099,080.00
210302	Түлш, халаалт	1,021,400.00
210304	Байрны түрээс	2,077,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,000.00
210401	Бичиг хэрэг	100,000.00
2105	Нормативт зардал	10,469,070.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,469,070.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	132,558,061.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	61,156,600.00
210602	Тавилга	10,133,103.00
210604	Урсгал засвар	61,268,358.00
2107	Томилолт, зочны зардал	5,680,227.00
210702	Дотоод албан томилолт	5,680,227.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,941,907.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,522,907.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	228,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,000,000.00
210807	Газрын төлбөр	191,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	950,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,682,040,025.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,213,210.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,213,210.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,675,826,815.61
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4,147,200.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,665,739,615.61
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,940,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,249,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,249,800.00
223001	Бусад хөрөнгө	24,639,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,610,800.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,933,987,114.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,933,987,114.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,299,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,645,320.53
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,821,042,193.71
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Билгүүн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг арилгах, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-аас 2021 оны 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын аудитын менежер Г.Гүнжидмаа анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлж, ахлах аудитор Р.Цолмон, аудитор Э.Энхбаатар, П.Амарсанаа, гэрээт аудитор М.Ганбаатар нар гүйцэтгэв.

Стандарт, хэмжил зүйн газар 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/145 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Стандарт, хэмжил зүйн газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс бүс нутаг, гадаад орны хүрээнд өргөжүүлэх;
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын хөтөлбөр, төсөл боловсруулах, техникийн зохицуулалтыг олон улсын жишгээр бий болгоход дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн төсөлд шүүлт хийх, эдгээр чиглэлийн дүрэм, журам, заавар, удирдамжаар хангах;
- Хэмжлийн нэгжийн олон улсын системд тулгуурласан үндэсний эталоны тогтолцоог хөгжүүлэх, нарийвчлалыг олон улсын түвшинд ойртуулах, үндэсний эталоноос нэгж дамжуулах тогтолцоог сайжруулан бэхжүүлэх;

- Итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, олон улсын итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлүүлэх;
- Сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх
- Олон улсын гэрээ хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт болон холбогдох норматив техникийн баримт бичгээс бүрдсэн үндэсний мэдээллийн сан бүхий төрийн мэдээллийн нөөц болох албыг байгуулан хөгжүүлэх;
- Бүтээгдэхүүн үйлчилгээ, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсын жишигт хүргэж, хөгжүүлэх;
- Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх, баталгаажуулалтын ажлын чанарыг олон улсын түвшинд ойртуулах.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Стандарт, хэмжил зүйн газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ тайлант онд шинэчлэн боловсруулсан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Стандарт, хэмжил зүйн газрын Стратегийн бодлого, төлөвлөлт дотоод аудитын газар 2020 онд харьяа 9 газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр зөвлөмж өгсөн байна. Харьяа газрууд өгсөн зөвлөмжийн дагуу “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” гарган хэрэгжилтийг үнэлж ажилласан байна.

Стандарт, хэмжил зүйн газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,928.7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 129.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2.7 сая, эцсийн үлдэгдэл 8.4 сая төгрөг болж 5.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	2.7	8.1	5.4	96.4
Арилжааны банк дахь харилцах	-	0.3	0.3	3.6
Дүн	2.7	8.4	5.7	100.0

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 8.1 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.3 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь, Төв аймгийн СХЗХ-үүдэд мөнгөн хөрөнгөтэй холбоотой 14.5 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн, төлбөрийн цахим систем дэх дүнгээс зөрүүтэй зэрэг 10.2 сая;
- Ажилтанд үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан олгосон 0.3 сая;
- Тайлант хугацааны эцэст цалингийн зардлын төсвөөс 2.4 сая, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 1.6 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 170.9 сая, эцсийн үлдэгдэл 140.8 сая төгрөг болж, 30.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	19.0	11.2	(7.8)	8.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	86.0	62.8	(23.2)	44.6
Татаас, санхүүжилтийн авлага	8.1	16.9	8.8	12.0
Бусад авлага	57.8	49.9	(7.9)	35.4
Дүн	170.9	140.8	(30.1)	100.0

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай Ховд аймгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн 0.1 сая төгрөгийн авлага байна. Нийт авлагын 48.9 хувь буюу 68.8 сая төгрөгийн авлага тайлант онд, 50.8 хувь буюу 71.5 сая төгрөгийн авлага өмнөх онд үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

Булган, Орхон, Сэлэнгэ, Төв, Ховд аймгийн СХЗХ-үүдэд авлага данстай холбоотой 6.1 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Баталсан төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс байгууллагаас авах 2.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- Тогтмол зардлын төсвийг өндөр төлөвлөж батлуулснаас оны эцэст үүссэн хэмнэлтийг дараа оны зардалд шилжүүлэн 3.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- НДШ, ХХОАТ-ын тооцоололтой холбоотой 0.6 сая;

- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын байцаагчийн тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг авлагаар бүртгээгүй, барагдуулсан эсэх нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 50.4 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урьдчилж гарсан зардал	-	5.5	5.5	10.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	44.9	44.9	89.1
Дүн	-	50.4	50.4	100.0

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд харьяа Дархан-уул аймгийн СХЗХ - 20.3 сая, Дорнод аймгийн СХЗХ – 24.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааг төлсөн байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,564.7 сая, эцсийн үлдэгдэл 1,367.4 сая төгрөг болж, 197.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалттай материал	207.7	250.3	42.6	18.3
Эм боох материал	11.7	18.3	6.6	1.3
Дуусаагүй үйлдвэрлэл	1,126.0	772.2	(353.8)	56.5
Бэлэн бүтээгдэхүүн	42.9	99.5	56.6	7.3
Хангамжийн материал	176.4	227.1	50.7	16.6
Дүн	1,564.7	1,367.4	(197.3)	100.0

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл буурсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэнтий аймгийн СХЗХ-ийн барилгын ажил дуусаж үндсэн хөрөнгөд шилжүүлснээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой нийт 31.1 сая төгрөгийн дараах зөрчлүүд байна.

- Баянхонгор аймгийн СХЗХ-ийн нярвын тайлан санхүүгийн тайлангийн бараа материалын үлдэгдлээс 0.2 сая төгрөгөөр илүү;
- Орхон аймгийн СХЗХ бараа материалын дансанд 1.8 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг бүртгэсэн;
- Төв аймгийн СХЗХ-ийн эд хөрөнгийн тооллогын комисс 9.4 сая төгрөгийн бараа материалыг тоолоогүй, 1.8 сая төгрөгийн хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэж бараа материалын дансанд бүртгэсэн;
- Хөвсгөл аймгийн СХЗХ 17.9 сая төгрөгийн бараа материалыг ангилж бүртгээгүй, бусад хангамжийн материалын дансанд бөөн дүнгээр бүртгэж нөөц үүсгэсэн.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,428.7 сая, эцсийн үлдэгдэл 6,922.6 сая төгрөг болж, 1,493.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	3,533.3	4,784.1	1,250.8	69.1
Авто-тээврийн хэрэгсэл	123.8	137.2	13.4	2.0
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,010.7	1,221.8	211.1	17.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	122.4	116.6	(5.8)	1.7
Зам, гүүрийн байгууламж	3.5	3.3	(0.2)	0.0
Бусад үндсэн хөрөнгө	47.6	66.8	19.2	1.0
Ном	6.1	6.6	0.5	0.1
Программ хангамж	136.6	100.7	(35.9)	1.5
Бусад биет бус хөрөнгө	444.7	485.5	40.8	7.0
Дүн	5,428.7	6,922.6	1,493.9	100.0

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 477.5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 889.8 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 10.8 сая, үндсэн хөрөнгийн капиталжуулалтаар 714.0 сая, бусад 63.0 сая, хөрөнгийн дахин үнэлгээгээр 69.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, худалдсан 42.3 сая, балансаас балансад шилжүүлэн өгсөн 14.7 сая, акталсан 204.2 сая, бусад 128.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 32.6 сая, эцсийн үлдэгдэл 54.6 сая төгрөг болж, 22.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	3.5	4.2	0.7	7.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2.3	1.2	(1.1)	2.2
Бусад өглөг	26.3	49.2	22.9	90.1
Урьдчилж орсон орлого	0.5	-	(0.5)	0.0
Дүн	32.6	54.6	22.0	100.0

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 49.2 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг байна.

Батлагдсан төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс тайлант онд 54.6 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

Аудитын илрүүлэлт:

Стандарт, хэмжил зүйн газар -36.5 сая, Төв аймгийн СХЗХ- 6.9 сая, Говь-Алтай аймгийн СХЗХ- 1.5 сая, Баян-Өлгий аймгийн СХЗХ-1.4 сая, Булган аймгийн СХЗХ-1.3 сая, Дорнод, Увс аймгийн СХЗХ- 1.2 сая, Завхан аймгийн СХЗХ- 1.1 сая, Дорноговь, Хэнтий аймгийн СХЗХ - 0.8 сая, Өвөрхангай аймгийн СХЗХ- 0.7 сая, Сүхбаатар аймгийн СХЗХ- 0.6 сая, Ховд аймгийн СХЗХ- 0.3 сая, Сэлэнгэ аймгийн СХЗХ-0.2 сая, Дундговь аймгийн СХЗХ-0.1 сая төгрөг.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,141.5 сая, эцсийн үлдэгдэл 8,435.8 сая төгрөг болж, 1,294.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,181.0	6,906.9	725.9	81.9
Хуримтлагдсан үр дүн	(1,098.0)	(536.9)	561.1	(6.4)
Өмнөх үеийн үр дүн	(1,587.5)	(1,091.4)	496.1	(12.9)
Тайлант үеийн үр дүн	489.5	554.5	65.0	6.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,058.5	2,065.8	7.3	24.5
Дүн	7,141.5	8,435.8	1,294.3	100

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 6,906.9 сая төгрөг болж 725.9 сая төгрөгөөр өссөн нь Хэнтий аймгийн СХЗХ-ийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилгын ажлыг хүлээн авч данс бүртгэлд тусгаснаас шалтгаалжээ.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 15.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан дараах зөрчлүүд байна.

Аудитын илрүүлэлт:

- Ховд аймгийн СХЗХ нь гэрэл цахилгааны зардлын зарцуулагдаагүй үлдэгдлээс 5.7 сая төгрөгийг цахилгаан халаалтын тогоо болон халаалттай холбоотой ажлыг гүйцэтгүүлэхээр олгосон боловч ажлын гүйцэтгэл дутуу.
- Булган аймгийн СХЗХ цалингийн зардлаас 1.1 сая төгрөгийн шагнал олгосон, ЗТХС-ын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоос 0.4 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан;
- Орхон аймгийн СХЗХ газар хөдөлгөөртэй Соната-7 автомашины шатахууны картаар дамжуулан 4.7 сая төгрөгийн АИ92 бензин, дизель түлш авч зарцуулсан;
- Төв аймгийн СХЗХ цар тахлын улмаас баталгаажуулалтын үйл ажиллагаа хийгдээгүй байхад бусдын тээврийн хэрэгслээр явж 0.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан;
- Хэнтий аймгийн СХЗХ нь ЗТХС-ын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоос 0.3 сая төгрөгийн шатахуун илүү, НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 1.0 сая, үндсэн үйл ажиллагааны зардлаас 2.3 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 7,721.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 965.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8,686.8 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь эд хогшил, урсгал засварын зардлыг 623.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталснаас шалтгаалжээ.

Төсвийн тодотголоор 8,666.8 сая төгрөг болгож улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Дорнод аймгийн СХЗХ-ийн барилгын төсвийг 20.0 сая төгрөгөөр бууруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 270 дугаар тогтоол, Шадар сайдын 2020 оны 82 дугаар тушаалаар Үндэсний итгэмжлэлийн төвийг байгуулж Стандарт, хэмжил зүйн газрын төсвийг 63.6 сая төгрөгөөр бууруулж 8,603.2 төгрөг болгосон байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 8,603.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 8,223.2 сая төгрөгийг урсгал зардалд, 380.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 4,281.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 4,321.7 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,258.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,444.0 сая төгрөг буюу 98.1 хувьтай байна.

Стандарт, хэмжил зүйн газар, харьяа байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлого 7,042.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 2,756.2 сая төгрөгөөр давсан нь Коронавируст халдварт (Ковид-19) цар тахалтай холбоотойгоор гадаад орноос тогтоосон хөл хорио, хилийн хязгаарлалтын улмаас дотоодын алт тушаалт, үнэт металлын сорьцын баталгаажуулалт нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үйл ажиллагааны давсан орлого 2,280.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Цаашид байгууллагын үйл ажиллагааны орлогыг тооцоо судалгаа, гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөх шаардлагатай байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар орон нутгийн хөгжлийн сангаас Баянхонгор аймгийн СХЗХ-т 5.0 сая, Засгийн газрын нөөц сангаас 24.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 83.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,821.1 сая, нийт 1,934.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эд хогшил, урсгал засварын зардалд 132.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 34.9 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 17.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 16.8 сая, нийт 258.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,675.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 173 мэдээллээс 86 мэдээллийг хугацаанд нь, 83 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: Дараа жилийн төсвийн төсөл, хандив зарцуулалтын мэдээ, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй байна.

3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяа 21 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3.9 сая төгрөгийн 10 төлбөрийн акт, 163.8 сая төгрөгийн 17 албан шаардлага, 26.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, алдааг давтан

гаргахгүй байх 26 зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 21 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 16 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагын санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан, 4 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 13, “Хязгаарлалттай” 3 /Орхон аймгийн СХЗХ, Ховд аймгийн СХЗХ, Хэнтий аймгийн СХЗХ/ дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар нийт 4,812.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,773.3 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 9.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 76.4 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 953.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас 1,709.2 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 5.7 сая төгрөгөөр эргэлтийн хөрөнгийг дутуу, 1.0 сая төгрөгөөр эргэлтийн бус хөрөнгийг дутуу, 0.02 сая төгрөгөөр өр төлбөрийн дансыг дутуу, 5.5 сая төгрөгөөр цэвэр хөрөнгө өмчийн дүнг илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 0.2 сая төгрөгөөр үйл ажиллагааны орлогыг дутуу, 5.7 сая төгрөгөөр Говь-алтай, Хэнтий аймгийн СХЗХ-ийн үйл ажиллагааны зардлыг дутуу, 15.6 сая төгрөгөөр Өмнөговь аймгийн СХЗХ-ийн үйл ажиллагааны зардлыг илүү, үйл ажиллагааны үр дүнг нэгтгэсэн;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд 1,675.8 сая төгрөгийн төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг цэвэр дүнгээр тусгаагүй.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагын залруулга:

- Стандарт хэмжил зүйн газар үйл ажиллагааны давсан орлого 1,691.8 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны зардал дансаар дамжуулан нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн;
- Дорнод аймгийн СХЗХ-ийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилгын эрх шилжүүлсэн гүйлгээгээр хийгдсэн дүнг хөрөнгийн зардлаар бүртгээгүй.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

1. Стандарт, хэмжил зүйн газар нь 1, 2 дугаар байрны их засварын ажлын захиалагчийн хяналтын зардал болох 9.6 сая төгрөгийг гүйцэтгэгч “Далу” ХХК-д илүү олгосон байгаа нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-д “Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралт “Барилгын ажлын захиалагчдын дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана” гэсэн заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

2. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого болох хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын 2020 оны 12 дугаар сарын орлого 76.4 сая төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл Санхүүгийн бүртгэл, стандарт 26.1 "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4 "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.5 "бүх орлого", 18 дугаар зүйлийн 18.1 "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 173 мэдээлэл байршуулахаас хугацаа хоцроосон 83 мэдээлэл, байршуулаагүй 4 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, 6 дугаар зүйл 6.1, 6.2, 6.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 953.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 263.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 22.1 сая төгрөгийн 15 алдааг аудитын явцад залруулж, 0.4 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 73.8 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 166.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 23 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Стандарт, хэмжил зүйн газар нь үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөдөггүй, аккрузл сууриар бүртгэсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 629.1 сая төгрөгийн их засварын ажлыг төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан урсгал засварын зардлын төсвөөс санхүүжүүлэн гүйцэтгүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих, чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 114 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.4 "Төсвийн урсгал зардлаас дараах зардлын санхүүжилтийг түр зогсоох", 3.4.1 "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомжийг мөрдөхгүй байх, төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулах;

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөлтийг үнэн зөв бодитой төлөвлөх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулсан.

4.2 Балансын холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

Өмнөх онуудад үүссэн 4 аж ахуйн нэгж, байгууллагаас авах төлбөртэй үйлчилгээний 47.2 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

4.2.2 Эрсдэл:

Авлага барагдахгүй, найдваргүй, эзэн холбогдогч тодорхойгүй, эргэн төлөгдөхгүй болох;

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, үүссэн авлагыг тухайн жилд нь барагдуулж байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулсан.

4.3 Балансын данстай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд ХХОАТ, НДШ-ийн 36.4 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

4.3.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлэхгүй байх;

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн өр төлбөрийн тухайн жилд нь барагдуулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулсан.

4.4 Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 263.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 22.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 73.8 сая төгрөгийн 11 албан шаардлага, 166.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 23 зөвлөмж хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх;

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах, дотоод хяналтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.03.25			САГ-2021/19/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Стандарт, хэмжил зүйн газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Стандарт, хэмжил зүйн газар нь 1, 2 дугаар байрны их засварын ажлын захиалагчийн хяналтын зардал болох 9.6 сая төгрөгийг гүйцэтгэгч "Далу" ХХК-д илүү олгосон.	9.6	Төлбөрийн акт тогтоосон	Дарга Нягтлан бодогч	Б.Билгүүн О.Оюунтуяа
2	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого болох хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын 2020 оны 12 дугаар сарын орлого 76.4 сая төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүй.	76.4	Албан шаардлага хүргүүлсэн	Ерөнхий нягтлан бодогч	Т.Энхтүвшин
3	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 173 мэдээлэл байршуулахаас хугацаа хоцроосон 83 мэдээлэл, 4 мэдээлэл байршуулаагүй.	-	Албан шаардлага хүргүүлсэн	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Билгүүн Т.Энхтүвшин
4	Өмнөх онуудад үүссэн 4 аж ахуйн нэгж, байгууллагаас авах төлбөртэй үйлчилгээний 47.2 сая төгрөгийн авлага барагдуулаагүй.	47.2	Зөвлөмж өгсөн	Ерөнхий нягтлан бодогч	Т.Энхтүвшин
5	Тайлант онд ХХОАТ, НДШ-ийн 36.4 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг үүсгэсэн.	36.4	Зөвлөмж өгсөн	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Билгүүн Т.Энхтүвшин
6	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 629.1 сая төгрөгийн их засварын ажлыг төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан урсгал засварын зардлын төсвөөс санхүүжүүлэн гүйцэтгүүлсэн.	629.1	Зөвлөмж өгсөн	Дарга Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч Эдийн засагч	Б.Билгүүн Т.Энхтүвшин О.Оюунтуяа Ч.Чимгээ
7	Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 263.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 22.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 73.8 сая төгрөгийн 11 албан шаардлага, 166.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 23 зөвлөмж хүргүүлсэн.	240.9	Зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	О.Оюунтуяа
	Дүн	1,039.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 03 дугаар сарын 25 № 100/АД/170079
СМГ-2021/19/СТН-ТТЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Стандарт, хэмжил зүйн газар нь 1,2 дугаар байрны их засварын ажлын захиалагчийн хяналтын зардал болох 9,637,910.00 /Есөн сая зургаан зуун гучин долоон мянга есөн зуун арван/ төгрөгийг гүйцэтгэгч "Далу" ХХК-д илүү олгосон байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-д "Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно", Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчдын дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.7-д "Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Далу" ХХК-д илүү олгосон захиалагчийн хяналтын зардал 9,637,910.00 /Есөн сая зургаан зуун гучин долоон мянга есөн зуун арван/ төгрөгийг тус байгууллагаар төлүүлэн Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхтүвшин нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АУДИТОР

Э.ЭНХБААТАР

АУДИТОР

П.АМАРСАНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0325auditin 2-R Gazar4.Docx

071090181



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 427/А0170079
СНТ- 2021/19/СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны сайтад нийт 173 мэдээлэл байршуулахаас хугацаа хоцроосон 83 мэдээлэл, байршуулаагүй 4 мэдээлэл байна.


Энэ нь Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхтүвшин нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Я.САМБУУНЯМ
Э.ЭНХБААТАР
П.АМАРСАНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 408/А0170079
СЭТ- 2021/19/СТА-ТТЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Стандарт, хэмжил зүйн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого болох хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын 2020 оны 12 дугаар сарын орлого 76,399,400.00 /далан зургаан сая гурван зуун ерэн есөн мянган дөрвөн зуун/ төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн Санхүүгийн бүртгэл, стандарт 26.1-т "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4 "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.5 "бүх орлого" 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийг аккрузл сууриар бүртгэж байх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Ерөнхий нягтлан бодогч Т.Энхтүвшин нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Э.ЭНХБААТАР
П.АМАРСАНАА